



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/147

Хэрлэн сум

Хүндэтгэл үзүүлж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Оросын Холбооны улсын Өвөр байгалийн хязгаарын Хүн ам, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны сайд А. М. Федотов тэргүүтэй төлөөлөгчдийн 2017 оны 04 сарын 18-20-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Чингис хотод хийх албан ёсны айлчлалын хүрээнд хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Төлөөлөгчдийг хүлээн авахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах 2479000 /хоёр сая дөрвөн зуун далан есөн мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас олгохыг Санхүү төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Зочид төлөөлөгчдийг хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 762

ӨВӨР БАЙГАЛИЙН ХЯЗГААРЫН ХҮН АМ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨЛӨӨЛӨГЧИД ХЭНТИЙ АЙМГИЙН ЧИНГИС ХОТОН
АЙЛЧЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо / ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	Шатахуун	Литр	220	1700	374000	
2	Өдрийн хоол	Хүнээр	10 хүн x 2 өдөр	20000	400000	Норовлин суманд, Ханбүргэд
3	Оройн хоол	Хүнээр	10 хүн x 1 өдөр	20000	200000	
4	Хүлээн авалт	Хүнээр	20 хүн	40000	800000	
	Зочид буудал	Бүтэн люкс өрөө	1 өрөө x 2 өдөр	75000	150000	
		Хагас люкс	1 өрөө x 2 өдөр	60000	120000	
5		Энгийн өрөө	2 өрөө x 2 өдөр	40000	160000	
6	Засаг даргын гарын бэлэг	Ширхэг	5	40000	200000	
7	Замын хүнс	Хүнээр	5	15000	75000	
	нийт үнэ				2479000	